



Батлав. Соёлын өвийн төвийн захирал

Г.Энхбат

“Монгол Улсын түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл”-ийг хөтлөх заавар

Нэг. Нийтлэг зүйл

1.1 Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 2 дугаар бүлгийн 6, 7, 8 дугаар зүйлд заасны дагуу соёлын өвийн улсын бүртгэл–мэдээллийн санг бүрдүүлэхэд Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны 541 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Монгол Улсын түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл”-ийг баримтлана.

1.2 Энэхүү зааврыг “Монгол Улсын түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл”-ийг үндэслэн боловсруулсан соёлын өвийн бүртгэлийн “Registration of Cultural Heritage буюу RCH” програмын дагуу музейн үзмэрийг бүртгэхэд мөн адил баримтлана.

1.3 Түүх, соёлын дурсгалт зүйлийг өмчлөгч, эзэмшигч нь “Монгол Улсын түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл”-ийг Монгол Улсын “Соёлын өвийг хамгаалах тухай” хууль, “Соёлын өвийн улсын бүртгэл-мэдээллийн санг бүрдүүлэх, уг санд бүртгэх” журам, түүх, соёлын дурсгалыг бүртгэхтэй холбогдон гарсан хууль, стандарт, эрх зүйн акт, баримтад нийцүүлэн үнэн зөв хөтлөнө.

1.4 “Монгол Улсын түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл”-ийг “Соёлын өвийн улсын бүртгэл-мэдээллийн санг бүрдүүлэх, уг санд бүртгэх журам”-ын 2.2, 2.3-д заасны дагуу Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санд /цаашид СӨУНБМС гэнэ/ ирүүлэх ба бүртгэлийн хувийг шат, шатны бүртгэл-мэдээллийн сан тус бүрд хадгална.

1.5 Монгол Улсын түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл нь Монгол Улсын соёлын өвийн бүртгэл-мэдээллийн сангийн бүрдлийг бодит мэдээллээр хангах зорилготой бөгөөд шат, шатны бүртгэл-мэдээллийн сангийн тулгуур эх баримт болно.

Хоёр. Бүртгэл хөтлөх

2.1 УБМСангийн дугаар:

Энэ дугаарыг зөвхөн Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн сангаас өгнө.

2.2 Өмчлөгч:

Тухайн дурсгалт зүйл төрийн өмч бол “Монгол Улс”, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмч бол тухайн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нэр бичигдэнэ. “Монгол Улс” гэж бичсэн тохиолдолд регистрийн дугаар буюу “РД” нүдэнд тэмдэглэгээ хийхгүй, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нэр бичигдсэн бол регистрийн дугаар бичигдэнэ.

2.3 Эзэмшигч:

Дурсгалыг эзэмшигч байгууллагын албан ёсны нэр, регистрийн дугаарыг бичнэ.

2.4 Дурсгалт зүйлийн оршин байгаа хаяг:

Дурсгалт зүйлийг өмчлөгч, эзэмшигчийн албан ёсны хаяг, “**Ашиглалтын байдал**” хэсэгт тухайн дурсгал хэрхэн ашиглагдаж, ямар танхим, сан хөмрөгт байгааг тэмдэглэнэ.

2.5 Дурсгалт зүйлийн нэр:

Тухайн дурсгалт зүйлийн нэрийг бичнэ. “**Орон нутаг, олон улсын (шинжлэх ухаан)-ын нэр**” хэсэгт олон нийтэд нийтлэг тархсан, орон нутагт угсаатан, ястны нэрлэж заншсан нэр болон олон улсад, шинжлэх ухааны эргэлтэд түгээмэл хэрэглэгддэг нэрийг бичиж болно.

2.6 Хувийн дугаар:

Дурсгалын дугаарыг бичнэ. Хэрэв музейн үзмэр бол “Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэл”-д бичигдсэн “Үзмэр, эд өлгийн зүйлийн хувийн дугаар”-ыг зөвхөн бичнэ.

2.7 Эх бүтээл, Хуулбар:

Тухайн дурсгал эх бүтээл болон хуулбар болохыг ялган “√” тэмдэглэгээг хийнэ.

2.8 Зэрэглэл:

Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 1 дүгээр бүлгийн 5 дугаар зүйлд заасны дагуу тухайн дурсгал зэрэглэлд тодорхойлогдсон бол зэрэглэлийн нэрийг, зэрэглэлд баталсан тогтоол, тушаалын дугаар, огноог “**Шийдвэр**” хэсэгт бичнэ. Дурсгал албан ёсоор зэрэглэлд хамрагдаагүй бол бичилт хийхгүй.

2.9 Төрөл зүйл:

Тухайн дурсгал ямар төрөл зүйлд хамаарагдахыг бичнэ. *СӨУНБМСангаас түүх, соёлын дурсгалт зүйлийн төрөл зүйлийн ангилалыг гаргасан байгаа болно.*

2.10 Он цаг:

Дурсгалт зүйлийг бүтээсэн болон холбогдох он цагийг бичнэ. Хэрэв бүтээсэн он цаг нь тодорхойгүй бол холбогдох он цагийг түүхэн он цагийн үечлэлд хамруулан бичнэ. *Түүхэн он цагийн үечлэлийг СӨУНБМСангаас гаргасан байгаа болно.*

2.11 Бүтээлч, сургууль хийц:

Тухайн дурсгалын бүтээлч, зохиогчийн овог, нэр, төрсөн /өнгөрсөн/ оныг баримт, судалгааг үндэслэн бичнэ. Зохиогч, бүтээгч нь тодорхойгүй бол бөглөхгүй.

Дурсгалын бүтээлчтэй холбоотой бусад баримт, мэдээллийг бүртгэлийн “Товч түүх”-ийн хэсэгт оруулж болно. Тухайн дурсгал ямар “**сургууль хийц**”-д хамрагдахыг тогтоосон бол нэмж тэмдэглэнэ. Тухайлбал: Монгол дархны урлал нь хийцээрээ боржигин, дарьганга, долнуур, ханхөхий, буриад, арчуул, ноёнсэврэй, авдарбаян, батноров гэж ангилагдсан байдаг.

2.12 Материал, арга ажиллагаа:

Дурсгалт зүйлийн хийсэн материалыг үнэн зөв таниж бичнэ. Дурсгалыг хийсэн үндсэн материалаас эхлэн нэмэлт болон эрдэнийн чулуу, үнэт металл зэрэг дагалдаж орсон материалыг тоочин бичнэ.

Тухайн дурсгалыг хийсэн “**арга ажиллагаа**” нь тодорхой, танигдсан бол нэмж тэмдэглэнэ.

2.13 Хэмжээ:

Дурсгалт зүйлийн хамгийн ерөнхий өндөр, өргөн /урт/, зузаан, голч, жинг эхний нүдэнд, дурсгалын деталь хэсгүүдийн хэмжээг үлдсэн нүднүүд, **бусад хэмжээс** хэсэгт бичнэ.

Мөн дурсгалын хэмжилтийг тэмдэглэсэн зургийг үйлдэн бүртгэлдээ хавсаргана. Хэмжээсийн зургийг үйлдэхдээ тухайн үзмэрийн бүрэн харагдах байдлаас нь хамааран 1-4 талаас харсан гэрэл зургийг хэвлэн гаргаад, түүн дээрээ дурсгалын бодит хэмжээсүүдийг тавина.

2.14 Иж бүрдэл:

Тухайн дурсгалт зүйл олон хэсгээс бүрдэж байгаа бол иж бүрдэл бүрийг нэрлэн тоо ширхэг, материал, хэмжээг нь бичнэ. **“Тоо ширхэг”** нүдэнд иж бүрдлийн нийт дүнг тоогоор бичих ба иж бүрдэлгүй бол тоо ширхэг нүдэнд “1” гэж бичнэ.

2.15 Анх цуглуулсан, нээж илрүүлсэн:

Тухайн дурсгалыг анх цуглуулсан, нээж илрүүлсэн иргэн, байгууллагын нэр, дурсгалын олдсон газар, он цаг зэргийг тодорхой бичнэ.

2.16 Хамгаалалтад авсан шийдвэр:

Тухайн дурсгалт зүйлийг музей болон байгууллагад авсан тушаал, протокол холбогдох бусад эрх зүйн баримтын дугаар, огноо зэрэг байна.

2.17 Гэмтэл:

Тухайн дурсгалт зүйлийн хаана нь ямар гэмтэлтэй болохыг хэмжээтэй нь тодорхой, тоочин бичнэ.

2.18 Зориулалт:

Дурсгалт зүйлийн язгуур зориулалт болон хэрхэн ашиглагдаж ирснийг бичнэ.

2.19 Ховор, түгээмэл байдал:

Тухайн дурсгалын ховор, түгээмэл эсвэл цорын ганц болох талаар бичнэ.

2.20 Гарал үүсэл:

Тухайн дурсгал хаанахын ямар гаралтай болохыг бичнэ.

2.21 Тодорхойлолт:

Дурсгалт зүйлийн өнгө, хэлбэр төрх, материал, ур хийц, гараар болон үйлдвэрийн аргаар хийсэн болохыг тодорхой оновчтой дүрслэн бичнэ. Тухайлбал: дурсгалын үнэт металл, эрдэнийн чулууны тоо ширхэг, материалын өнгө, өөрчлөлт, хувирал зэргийг бичиж болно.

Дурсгалын онцлог шинж болох гарын үсэг, таних тэмдэг, он, дардас, тамга, тэмдэг, бичиг, бичээс, сорьцын тэмдэглэгээ зэрэг нь дурсгалын аль хэсэгт байгааг зааж, дүрслэн бичих ба шаардлагатай бол зурж тэмдэглэнэ.

2.22 Товч түүх:

Тухайн дурсгалыг хэн, хэрхэн бүтээсэн тухай, хэнээс хэнд дамжин хадгалагдаж ирсэн талаар болон музейд худалдаа, солилцоо, хандив, шилжүүлэг зэрэг ямар хэлбэрээр хэзээ орж ирсэн, хэн өгсөн, авсан талаар бичнэ.

Дурсгал хулгайд алдагдаж байсан, шагнал хүртсэн тухай мэдээлэл, түүнчлэн дурсгалтай холбоотой аман яриа, таамаглал байгаа бол хэний яриа болохыг бичнэ.

Дурсгалын нэр, он цаг, материал зэрэг нь музей, байгууллагын бүртгэлд алдаатай, зөрүүтэй бичигдсэн бол залруулга тайлбарыг бичих, дурсгалын дугаар өөрчлөгдсөн, шинэчлэгдсэн, хүчингүй болсон тухай мэдээллийг мөн энд оруулна.

2.23 Сэргээн засварласан байдал:

Дурсгалт зүйлийн сэргээн засварлагдсан эсэх, сэргээн засварлагдсан бол сэргээн засварлуулах тухай шийдвэр, хэзээ, хаана, хэн хийж гүйцэтгэсэн болон сэргээн засварласан баримтын дугаарыг **СЗБ №** нүдэнд бичнэ.

2.24 Хуулбар хийгдсэн байдал:

Дурсгалт зүйлийн хуулбар хийгдсэн эсэх, хуулбар хийгдсэн бол хуулбар хийлгэх тухай шийдвэр, хэзээ, хаана, хэн хийж гүйцэтгэсэн, хэдэн хуулбар хийгдсэн, эх бүтээл нь хаана хадгалагдаж байгаа зэргийг бичнэ.

2.25 Шилжилт хөдөлгөөн:

Тухайн дурсгалт зүйлийн шилжилт хөдөлгөөнд орсон (үзэсгэлэн, судалгаа шинжилгээ, солилцоо, сэргээн засварлалтад явсан) тухай шийдвэр, хэзээ, хаашаа, ямар хугацаатай явсан тэмдэглэгээг хийнэ.

2.26 Судлагдсан байдал:

Тухайн дурсгалын талаар гарсан ном зохиол, эрдэм шинжилгээний өгүүлэл, сонин сэтгүүлийн нийтлэл зэргийн зохиогч, нэр, оныг тоочин бичнэ.

2.27 Хавсралт материалын тэмдэглэл:

Тухайн дурсгалын хэмжилтийн зураг, бүртгэлийн асуулгуудын нэмэлт хуудас, холбогдох бусад баримт (хэвлэгдсэн материал, судалгааны ажил, тайлан зэргийн эх болон хуулбар хувь)-ыг бүртгэлд хавсаргаж тэмдэглэнэ.

2.28 Бүртгэсэн:

Бүртгэлийг хөтлөсөн хүний овог, нэр, албан тушаал, бүртгэлийг хийсэн он, сар, өдөр бичигдэнэ.

2.29 Байгууллага, сум, дүүрэг, аймаг, нийслэл, улсын нэгдсэн (доогуур зур) бүртгэл-мэдээллийн санд хадгалагдаж байгаа гэрэл зураг, негатив хальс, дуу дүрс бичлэгийг хуурцаг, CD/DVD/BD, архив ном, хэвлэлийн баримт, бусад:

Бүртгэлийг бүрдүүлж байгаа бүртгэл-мэдээллийн сан нь нэрийнхээ доогуураа зурж тодотгоно. Байгууллага, сум, дүүрэг, аймаг, нийслэл, улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн сан нь түүх, соёлын дурсгалт зүйлийн холбогдолтой гэрэл зураг, негатив хальс, дуу дүрс бичлэгийн хуурцаг, CD/DVD/BD, архив, ном, хэвлэлийн баримт, судалгааны ажил, тайлан, холбогдох бусад материалаа хавтаслан, хадгаламжийн нэгж үүсгэн хадгална.

Тухайн дурсгалын холбогдох материал уг хадгаламжид ямар дугаартай байгааг бүртгэлийн “**хадгаламжийн дугаар**” нүдэнд, энэ нь хэдэн ширхэг, хэдэн хуудастай болохыг “**тоо ширхэг**” нүдэнд тус тус бичнэ.

2.30 Бүрдүүлэлт хийсэн:

Дээрх баримт, материалыг бүрдүүлсэн хүний овог нэр, албан тушаал, бүрдүүлэлт хийсэн он, сар, өдөр бичигдэнэ.